



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн тогтоох нь:

1. “Төв авто замын засвар арчлалт” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 33,495,360.00 (гучин гурван сая дөрвөн зуун ерэн таван мянга гурван зуун жаран) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Төв авто замын засвар арчлалт” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Болдбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах, худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автокраныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2024 оны 8-р дугаар сарын 2-ны өдрийн  
9.5-дугаар тогтоолын хавсралт

"ТӨВ АВТО ЗАМЫН ЗАСВАР АРЧЛАЛТ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

| №        | Үндсэн хөрөнгийн нэр, марк  | Ашиглалтад<br>орсон огноо | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ, хуримтлагдсан<br>элэгдэл (төгрөг)                         |
|----------|-----------------------------|---------------------------|-------------|------------|-------------------------------------------------------------------------|
| 1        | Автокран Хьюндай, ТӨВ 45-92 | 1995                      | Ширхэг      | 1          | 33,495,360.00                                                           |
| Нийт дүн |                             |                           |             |            | 33,495,360.00                                                           |
|          |                             |                           |             |            | (гучин гурван сая дөрвөн зуун<br>ерэн таван мянга гурван зуун<br>жаран) |